

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.07.09-07.13

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын компаниудын хувьцааны ханш долоо хоногийн турш хэлбэлзсэн ч өсөлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг мэдээлэл технологийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн бол өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш унажээ.

Хувьцаат компаниудын 2-р улирлын санхүүгийн тайлан олон нийтэд ил болох үе тохиож, хувьцаат компаниудын хувьцаа бага хэмжээгээр арилжигдав. Баасан гарагт АНУ-ын томоохон гурван банкны тайлан олон нийтэд ил болсон байна.

Худалдааны маргаан аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ өсөхөд нөлөөлөв. Ройтерс агентлагийн мэдээлснээр, АНУ-ын үйлдвэрлэгчийн үнийн индекс сүүлийн долоон жилийн хугацаанд үзэгдээгүйгээр түргэн буюу 3.4%-аар өссөн ажээ. Гаалийн татвартай холбоотойгоор барилга, аж үйлдвэрийн салбарт ашиглагддаг ган, хөнгөн цагааны үнэ нэмэгдэж үйлдвэрлэгчдийн зардал өсжээ.

Хэрэглээний үнийн индекс 6-р сард өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.9%-аар өссөн нь сүүлийн 6 жилийн хугацаанд үзэгдээгүй өндөр үзүүлэлт юм. Мөн АНУ-ын иргэд инфляцийн түвшин цаашид өснө гэсэн хүлээлттэй байгаа ажээ.

Европ: Европын компаниудын хувьцааны ханш худалдааны маргаан болон Брекситийн хэлэлцээрийн тодорхойгүй байдлаас үл хамааран өсөлттэй хаагдлаа. Газрын тосны үнийн огцом уналт зах зээлд төдийлөн нөлөөлөөгүй ба хувьцаат компаниудын 2-р улирлын санхүүгийн тайлангийн эерэг үзүүлэлтүүд зах зээлийн индекс өсөх гол шалтгаан болсон байна.

Хөл бөмбөгийн ДАШТ-тэй холбогдуулан Их Британийн иргэдийн үзвэр үйлчилгээнд зарцуулж буй хэрэглээний зардал нэмэгджээ. 6-р сард тус улсын жижиглэнгийн бараа бүтээгдэхүүний борлуулалт өмнөх оны мөн үеэс 2.3%-аар өссөн байна. Английн эдийн засгийн 80 хувийг хэрэглээний зардал бүрдүүлдэг учраас жижиглэнгийн худалдааны өсөлт эдийн засагт эерэг нөлөө үзүүлж байгаа ажээ.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдлаа. Иенийн ханш ам. долларын эсрэг 112.5 нэгж хүрч хаагдав.

Япон улсын Засгийн газар санхүүгийн байдлаа сайжруулах арга хэмжээ авахгүй бол 2025 онд тус улсын төсвийн алдагдал 2.4 их наяд иенд хүрэх таамагтай байна. Харин Засгийн газар тус онд төсвийн ашигтай ажиллах зорилттой байгаа аж.

Газрын тос, нүүрсний үнэ болон импорт нэмэгдэж, бөөний худалдааны борлуулалт 2.8% өсжээ. Тус өсөлт нь Япон улсын инфляцийн түвшин өсөх гол шалтгаан болов.

БНХАУ: АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар БНХАУ-ын 200 тэрбум ам.доллартай тэнцэх импортын хувцас, тавилга зэрэг бараа бүтээгдэхүүнд ахин 10 хувийн гаалийн татвар ногдуулах талаар мэдээлсэн нь тус орнуудын хоорондын худалдааны маргааны асуудлыг хүндрүүлжээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,873.78	1.68% ▲
Dow Jones	АНУ	25,019.41	2.30% ▲
S&P 500	АНУ	2,801.31	1.50% ▲
Nasdaq	АНУ	7,825.98	1.79% ▲
S&P/TSX	Канад	16,561.12	1.16% ▲
FTSE 100	Их Британи	7,661.87	0.58% ▲
S&P/ASX 200	Австрали	6,268.40	-0.06% ▼
Nikkei 225	Япон	22,597.35	3.71% ▲
Hang Seng	Хонг Конг	28,525.44	0.74% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	109.48
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	96.34
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	95.18
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.44
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.57
TDBM' 2020	USD	9.3%	105.92

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.073	-0.01 ▼
Libor 3M	2.336	0.00 ▲
Libor 6M	2.521	0.01 ▲
Libor 1YR	2.787	0.01 ▲
US 6M Bond	2.154	0.05 ▲
US 2YR Bond	2.578	0.03 ▲
US 3YR Bond	2.652	0.01 ▲
US 5YR Bond	2.725	-0.01 ▼
US 10YR Bond	2.827	-0.01 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.07.10	Өөрчлөлт
USD	2,461.66	-0.07% ▼
CNY	372.02	0.45% ▲
EUR	2,891.34	0.30% ▲
RUB	39.43	1.02% ▲
KRW	2.21	0.45% ▲
JPY	22.16	-0.54% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,242.32	-1.05% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	15.83	-1.37% ▼
Зэс	USD/lb.	278.45	-1.40% ▼
Нүүрс	USD/MT	114.38	1.11% ▲
WTI газрын тос	USD/bbl.	70.75	-4.29% ▼
Brent газрын тос	USD/bbl.	75.1	-2.61% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.77	-2.81% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. V	6.10%
Бодлогын хүү	2018. V	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. V	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. V	12.60%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. V	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. V	18.70%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. V	10.10%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 32 компанийн 159 сая төгрөгийн 555,921 ширхэг хувьцаа арилжигдав.

“Монинжбар” /MIB/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсч 195.5 төгрөгт хүрч хаагдсан бол “Эрдэнэт авто зам” /EAZ/ компанийн хувьцаа 14.72%-аар буурч 840 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй байна.

7-р сарын 10-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,444.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,873.78 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.68%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	159.0
Зах зээлийн үнэлгээ	2,444,815.7

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,873.78	1.68% ▲
MSE I индекс	9,657.23	1.86% ▲
MSE II индекс	9,711.72	0.63% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Монгол базальт	112,489	43,433,673
Эрдэнэ ресурс	57,816	37,269,978
Девелопмент Корп		
АПУ	59,358	34,543,696
ЛэндМН ББСБ	278,188	16,129,125
Таван толгой	478	4,586,140

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монинжбар	195.50	15.00% ▲
Баялаг налайх	357.00	14.79% ▲
Бинсэ	400.00	14.29% ▲
Ремикон	40.00	10.80% ▲
Говь	25,500.00	6.34% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Эрдэнэт авто зам	840.00	-14.72% ▼
Хишиг уул	810.00	-14.68% ▼
Увс чацаргана	850.00	-13.27% ▼
Материалимпекс	9,000.00	-5.16% ▼
Жуулчин дюти фрий	86,800.00	-3.98% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
БиДиСек	62,978,410
Гаули	45,639,334
Голомт Капитал	39,692,059
Ти Ди Би Капитал	28,506,622
Ард капитал групп	27,169,220

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	595.00	633,188
Таван толгой	9,700.00	510,852
МИК	10,250.00	212,271
Говь	25,500.00	198,929
Сүү	217.74	74,903

ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
2	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
3	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
4	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с	Тодорхойгүй
5	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с	Тодорхойгүй
7	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
8	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
10	SUL	Жуулчин дүйти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с	Компанийн байранд
11	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с	Тодорхойгүй
12	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с	Компанийн байранд
13	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
14	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
15	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
16	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор	Тодорхойгүй
17	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
18	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
19	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с	Компанийн байранд
20	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с	Компанийн байранд
21	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
22	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
23	ТАН	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
24	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
25	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов	Компанийн байранд
26	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувьцааг худалдан авах тендер санал

Монгол Улсын Засгийн Газар нь 2018 оны 04 дүгээр сарын 19-ны өдрөөс “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувьцааны хяналтын багцыг дангаараа эзэмшигч болсон тул “Компанийн тухай” хуулийн 57.1, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 22.1.2 болон СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-ыг үндэслэн үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Монгол Улсын Засгийн газрын эзэмшлийн 94.67 хувь буюу 24,491,390 ширхэгээс бусад хэсгийг худалдан авах санал гаргаж байна. Үүнд:

Худалдан авахаар санал гаргасан хувьцааны тоо ширхэг: 1,378,886 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2018.07.09

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2018.09.19

Нэгж хувьцааны худалдан авах үнэ: 542.00 төгрөг

Төлбөрийг гүйцэтгэх хугацаа: 2018.09.20

Хувьцааг худалдан авах санал гаргагч: Монгол Улсын Засгийн газар

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Давхар бүртгэлтэй үнэт цаасыг хил дамжуулан арилжаалах чиглэлээр хамтран ажиллах хүсэлтийг СЗХ-нд хүргүүлээ

Монголын хөрөнгийн зах зээлд сүүлийн жилүүдэд гарсан томоохон ахиц дэвшлүүдийн нэг нь үнэт цаасны давхар бүртгэлийн ажиллагааг зохицуулах журмыг СЗХ, МХБ хамтран боловсруулж, хамгийн эхний давхар бүртгэлийн компани болох Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Эрдэнэ ресурс девелопмент корпорейшнийг МХБ-д бүртгэсэн явдал билээ. Тус компанийн хувьцаа нь одоогийн байдлаар гадаад, дотоодын захуудын хооронд хөрвөн арилжаалагдах боломжгүй байгаа хэдий ч Үнэт цаасны зах зээлийн тухай хуулинд хориглосон заалт байхгүй, журмаар зохицуулан хил дамнуулан арилжих боломж нээлттэй байна. Хувьцааг хил дамнуулан арилжаалах зохицуулалтыг бий болгосноор ханшийн тэнцвэртэй байдлыг хангах, дотоодын зах зээлд нийлүүлэлт нэмэгдэх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой тул холбогдох журмыг боловсруулах чиглэлээр зах зээлийн мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллах саналыг СЗХ-нд хүргүүлээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “В” болгож, дээшлүүлэв

Олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний “Фитч” агентлаг 2018 оны 7-р сарын 09-ний өдөр Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В-” байсныг “В” болгон дээшлүүлж, төлөвийг “Тогтвортой” болгов.

Ийнхүү зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэхдээ тус агентлаг дараах үндэслэлийг авч үзсэн байна.

Төсвийн гүйцэтгэл, тоон үзүүлэлтүүд 2017 оны 11-р сараас хойш тогтмол сайжирч 2018 оны 5-р сард төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 26% өссөн. Мөн төсвийн зарлага 6%-д хүрсэн нь 2018 оны зорилтот түвшинд хадгалагдаж байна. Фитчийн зүгээс төсвийн алдагдал 2018 оны эцэст ДНБ-ний 3.9%-д хүрч бууран, улмаар Засгийн газрын нийт өр ДНБ-ний 75.3% (2017 онд 81.2%, 2016 онд 91.4% байсан) хүртэл буурна гэсэн төсөөлөлтэй байна.

Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн Захирлуудын зөвлөл гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хэрэгжилтийн дөрөв дэх шатны үнэлгээг 6 дугаар сард хэлэлцэж баталсан ба хөтөлбөрийн хэрэгжилт сайн, 2018 оны 3-р сарын байдлаар бүх тоон үзүүлэлтүүд амжилттай хангагдсан болохыг тэмдэглэсэн. Ийнхүү ОУВС цаашлаад бусад донор орнууд болон хөрөнгө оруулагчдын санхүүжилтүүд үргэлжлэн хийгдэх боломж бүрдсэн.

Монгол Улсын гадаад валютын нөөц 2017 оны эхээр 1 тэрбум ам.долларттай тэнцэж байсан бол ОУВС-ын хөтөлбөртэй уялдаатайгаар санхүүжилтүүд хийгдсэнээр 2018 оны 5-р сарын байдлаар 3.3 сая ам.долларт хүрч өслөө.

Хэрэглээ болон уул уурхайн салбарын хамааралтай хөрөнгө оруулалтууд нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт үргэлжлэн сайжирч 2018 оны 1-р улиралд 6.1%-д хүрсэн. Энэ оны 4-р сард Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх БНХАУ-д айлчилсанаар, хил дээрх маргаан шийдвэрлэгдэж, нүүрс болон зэсийн нийлүүлэлтүүд эрчимжлээ. Фитч агентлагаас Монгол Улсын бодит ДНБ-ийг 2018 оны эцэст 5.2%, 2019 онд 6.3%-д хүрэх төсөөлөлтэй байгааг мэдэгдсэн байна. Монголбанк өнгөрсөн сард 2,182 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 356 кг-аар нэмэгдсэн байна.

Тодруулбал өнгөрсөн оны зургадугаар сард Монголбанк 1,826 кг алт авч байжээ. Түүнчлэн Монголбанк 2018 оны эхний хагас жилийн байдлаар 7,1 тонн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 430 кг-аар их буюу 6 хувийн өсөлт үзүүлсэнийг албаныхан онцлов.

Монголбанкны 1 грамм алтны дундаж үнэ 100 мянга 41 төгрөгийн ханштай байна.

Эх сурвалж: Монголбанк

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.